



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 06 сарын 24 өдөр

Дугаар A/53

Баян-Өндөр сум

Тусгай зөвшөөрөл шинээр олгох, хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3, 19.17, 19.18, 19.20, Зөвшөөрлийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1, 5.3 дугаар зүйлийн 1, 5.5 дугаар зүйлийн 10, 6.2 дугаар зүйлийн 1.7 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2023 оны “Журам шинэчлэн батлах, тушаалд өөрчлөлт оруулах тухай” А/383 тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн газрын дэргэдэх “Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комисс”-ын 2024 оны 06 дугаар сарын 20-ний өдрийн 07 дугаар хурлын шийдвэрийн дагуу шинээр олгох байгууллагуудыг нэгдүгээр, хүчингүй болгох байгууллагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл мэндийн газарт сар бүрийн мэдээ тайланг хугацаанд нь ирүүлж, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага, стандартуудыг хэрэгжүүлэн ажиллахыг эрүүл мэндийн байгууллагуудын захирал, дарга нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Удирдлага төлөвлөтийн хэлтсийн Бодлого төлөвлөлт хууль эрх зүй, тусгай зөвшөөрөл хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Уртнасан-д даалгасугай.

ДАРГА



Ц.МӨНХЦЭЦЭГ

Эрүүл мэндийн газрын даргын
2024 оны 06 дүгээр сарын 24-
ний өдрийн 4/10 дугаар
тушаалын нэдүгээр хавсралт



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР ОЛГОХ БАЙГУУЛЛАГЫН НЭР,
ЧИГЛЭЛ, ХУГАЦАА

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Хаяг, байршил	Хугацаа
1	Мөнгөн уул ХХК-ын "Хатагтай" клиник	Нөхөн үржихүйн тусламж үйлчилгээний	Уурхайчин баг, 3-17 – ны байрны 98 тоот	3 жил
2	Гүүд удам ариутгал ХХК – ын "Гүүд удам"	Ахуйн шавьж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх үйлчилгээ эрхлэх	Оюут баг Хаан банкны хажуу талын байр	3 жил

Эрүүл мэндийн газрын даргын
2023 оны 06 дүгээр сарын 24
-ний өдрийн 102 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт



ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ БАЙГУУЛЛАГЫН НЭР, ЧИГЛЭЛ

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Байршил
1	Урандөш Оргил ХХК-ын "Гэгээн үйлс" клиник	Арьс харшлын тусламж үйлчилгээ	Булаг баг, Ахмадын сувилал дотор
2	Хунтхайрхан ХХК-ын "Хунтхайрхан"	Ахуйн шавьж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх үйлчилгээ эрхлэх	Оюут баг Хаан банкны хажуу талын байр